



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/10

Хэрлэн сум

Үнэлгээний хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.3, 50.4, 50.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих Биндэр, Баянмөнх, Дэлгэрхаан сумын төв доторх 8.4 км автозамын ажлын зураг төсөл боловсруулах, Хэрлэн суманд цэвэр усны эх үүсвэрийн худаг шинээр гаргах, нөөцийн сан байгуулах зураг төсөл боловсруулах үйлчилгээний ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга: Э.Мөнх-Эрдэнэ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга

Нарийн бичиг: Ц.Мягмар-Ариунаа

Орон нутгийн өмчийн газрын
худалдан авах ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Э.Элбэг-Эрдэнэ

Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын
мэргэжилтэн

Х.Гонгор

Иргэний төлөөлөл

Д.Оюун

Төрийн бус байгууллагын
төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Э.Мөнх-Эрдэнэ) -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ